



СОНОМЫН ШАГДАР

Улаанбаатар хотын захиргааны дарга
1942-1944 он

Хуучин Сэцэнхан аймгийн Өндөрхаан уулын хошуу одоогийн Хэнтий аймгийн Идэрмэг сумын нутагт 1910 онд төрсөн. Багадаа гэрийн багшаар монгол бичиг заалгаж суралцсан.

1930-аад онд цэргийн албанд орж хугацаат албаны цэрэг, бага, дунд тушаалын дарга болж 1939 онд Халх голын байлдаанд оролцож явжээ. МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгч, БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгч, Сайд нарын Зөвлөлийн гишүүдийн хамтран хуралдсан хурлын 1939 оны 12, 68, 39 дүгээр тогтоолоор тус улсын зүүн хязгаарт Японы самуурай нартай баатарлагаар байлдаж, өөрийн эх орныг батлан хамгаалах хэрэгт үнэнч гавшгайчаар зүтгэж шалгарагсдын дотроос тавин шинэ хүчнийг улсын хариуцлагатай ажилд дэвшүүлэн ажиллуулахад бэлтгэж ирүүлэхийг Цэргийн

яаманд даалгасан ёсоор энэ завсар 21 хүнийг хүлээн авч, Намын Төв Хороо, Бага хурал, Засгийн газраас тусгай комисс томилж, уг хүмүүсийн чадвар байдлыг танилцан үзэж, ямар ажилд тэнцэхийг боловсруулсан төлөвлөгөөнөөс үндэслэн эдгээр шинэ хүчнүүд хэн хэнийг ямар ажилд томилох тухай хэлэлцээд мөн тогтоолын 4 дүгээр зүйлээр нөхөр Шагдарыг хотын захиргааны орлогч даргаар томилж, гэрэл зурагтай нь "Үнэн" сонины 1939 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 117 дугаарт нийтэлсэн байна.

Хотын захиргааны орлогч даргаар гурван жил ажиллаад 1942 онд хотын захиргааны даргаар дэвшин 1944 он хүртэл ажиллаж байгаад сургуульд суралцах болсон учир БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 82 дугаар хурлын тогтоолын 5 дугаар зүйлээр Улаанбаатар хотын захиргааны даргаас чөлөөлөгджээ.

1944-1949 онд БНМАУ-ын СнЗ-ийн Улсын хянан шалгах комисст улсын байцаагчаар ажиллаж байгаад биеийн эрүүл мэндийн байдлаас чөлөөлөгдөж, удалгүй нас баржээ.